


БАТЛАВ
 “ДЦС-4” ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
 ЗАХИРАЛ  Ү.ТӨМӨРХУЯГ
 2021 оны 3 сарын 26 өдөр

БАТЛАВ
 “БИ ЭЛ БИ ЖИ” ХХК-ийн
 ЗАХИРАЛ  Г.БАТ-ӨЛЗИЙ
 № 4 /2021-60
 Улаанбаатар хот

ХУУРАЙ ҮНС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Энэхүү гэрээг нэг талаас “ДЦС-4” ТӨХК-ийг төлөөлж БҮЭД захирал Б.Сандуйжав /цаашид “худалдагч” гэх/ нөгөө талаас “БИ ЭЛ БИ ЖИ.” ХХК-ийг төлөөлж захирал Г.Бат-Өлзий /цаашид “худалдан авагч” гэх/ нар нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Энэхүү гэрээгээр худалдан авагчийн захиалгын дагуу цахилгаан шүүлтүүрээр ялгасан хуурай үнсийг /цаашид “бараа” гэх/ худалдагч бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч үнийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой үүссэн харилцааг зохицуулна.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажсанаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 2.2 Талууд харилцан тохиролцсоноор энэхүү гэрээг 2021 оны 03-р сарын 23-ны өдрөөс 2021 оны 12-р сарын 31 -ний өдөр дуустал хугацаатай дор дурьдсан нөхцөлтэйгээр энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав

Гурав. Төлбөр, тооцоо

- 3.1 Талууд хоорондоо тохиролцсон худалдах, худалдан авах **1 тонн үнсний НӨАТ тооцсон үнийг** дараахь байдлаар тооцно.
 Станцын хашаан доторх үнэ **17,500₮**
 Станцын тээврийн хэрэгслээр 1-50 км дотор тээвэрлэсэн тохиолдолд **25,000төгрөг**
 51-150 км дотор тээвэрлэсэн тохиолдолд **31,500төгрөг**
- 3.2 Бараа бүтээгдэхүүний захиалсан хэмжээгээр нэхэмжлэхийг үндэслэн ДЦС-4 ТӨХК-ийн дансанд болон кассанд бэлнээр төлнө. Худалдан авагч үнсний төлбөрийг 3.3-т заасны дагуу төлнө.
- 3.3 Төлбөр тооцоо хийх хугацааг дараахь хүснэгтэд заасны дагуу гүйцэтгэнэ.

№	Худалдан авагч талын төлбөр хийх нөхцөлүүд	“ДЦС-4”ТӨХК-ийн тээврээр	Өөрийн тээврээр
1	Урьдчилж төлбөр хийх	+	+
2	Дараагийн ачилтын өмнө эхний ачилтын төлбөрөө хийсэн байх		+
3	Сар бүрийн сүүлийн 7 хоногийн ажлын эхний 3 хоногт багтаан үлдэгдэл төлбөрийг хийх	+	+

Худалдагч:

Худалдан авагч:



Дөрөв. Худалдагч талын эрх, үүрэг

- 4.1. Худалдагч тал гэрээний хугацаанд нийлүүлсэн барааны үнийг худалдан авагчаас нэхэмжлэх эрхтэй.
- 4.2. Худалдан авагч тал гэрээнд заасан хугацаанд төлбөрийн тооцоог бүрэн барагдуулаагүй бол худалдагч тал цаашид барааг нийлүүлэхгүй байх эрхтэй.
- 4.3. Худалдагч тал зориулалтын бус тээврийн хэрэгслээр үнс ачуулахгүй байх эрхтэй.
- 4.4. Худалдагч тал НМХГ-тай хийсэн "Санамж бичиг"-т заасны дагуу худалдан авагч талтай гэрээ хийж хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 21 хоногийн дотор НМХГ-аар цацрагийн хяналтын шинжилгээ хийлгэж, гарсан дүгнэлтийн хуулбар хувийг хавсаргасан албан тоотыг худалдагч талд хүргүүлэхийг худалдан авагч талаас шаардах эрхтэй. Хэрэв заагдсан хугацаанд мэдээлэл ирүүлээгүй бол бараа нийлүүлэх ажлыг зогсоож, гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
- 4.5. ДЦС-4 ТӨХК-ийн Хяналтын албанаас тавьсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, Аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
- 4.6. Станцын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, эд зүйл эвдсэн, хулгайлсан, архи уусан, хэв журмын зөрчил гаргасан гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээг цуцлах эрхтэй.
- 4.7. "ДЦС-4" ТӨХК-ийн тээврийн хэрэгслээр үнс авах захиалга өгсөн тохиолдолд худалдан авагч захиалгын дагуу барааг гэрээнд заасан хэмжээгээр, тогтоосон хугацаанд нийлүүлэх үүрэгтэй.
- 4.8. Техникийн шалтгаанаар, тодорхой хугацаанд барааг нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд худалдан авагч талд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
- 4.9. Худалдагч тал барааг худалдах талаар мөрддөг журмын заалтуудын дагуу худалдан авагчид шаардлага тавих үүрэгтэй.

Тав. Худалдан авагч талын эрх, үүрэг

- 5.1. Гэрээгээр тохиролцсон барааг захиалгын дагуу, тогтоосон хугацаанд нийлүүлэхийг худалдагч талаас шаардах эрхтэй.
- 5.2. Худалдан авагч тал "ДЦС-4" ТӨХК-ийн тээврийн хэрэгслээр үнс авах захиалга өгөх эрхтэй.
- 5.3. Худалдан авагч тал барааны үнийг сар бүрийн сүүлийн 7 хоногийн ажлын эхний 3 хоногт багтаан үлдэгдэл төлбөрийг бүрэн дуусгаж, төлбөрийн тооцоогүй болсон байх үүрэгтэй.
- 5.4. Үүргээ гүйцэтгээгүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд гэрээгээр тогтоосон хэмжээгээр алданги төлөх үүрэгтэй.
- 5.5. Худалдан авагч тал худалдагч талаас гаргасан барааг холбогдох журамын заалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй.
- 5.6. Худалдан авагч тал нь гэрээ хийгдэж хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 21 хоногийн дотор НМХГ-аар цацрагийн хяналтын шинжилгээ хийлгэн, гарсан дүгнэлтийн хуулбар хувийг хавсаргасан албан тоотыг худалдагч талд хүргүүлэх үүрэгтэй.
- 5.7. НМХГ-ын үйл ажиллагаатай холбоотойгоор шинжилгээний дүгнэлт хүргүүлэх хугацаа хойшилсон бол шалтгааныг тодорхойлж баталгаажуулсан албан тоотыг гэрээний 5.6-д заагдсан хугацаанд НМХГ-аар гаргуулан худалдагч талд хүргүүлэх үүрэгтэй.
- 5.8 Худалдан авагч нь ДЦС-4 ТӨХК-нд дараахь дугаартай тээврийн хэрэгсэлийг нэвтрүүлнэ
Үүнд: 17-64 УБЭ. 39-53

Худалдагч :

Худалдан авагч:



5.9 Худалдан авагч нь тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж, замын хөдөлгөөний дүрмийг чанд сахиж ажиллана.

5.10 Худалдан авагч талын ажиллагсад хулгай хийсэн болон хулгайн хэрэгт холбогдсон нь тогтоогдвол хулгайлсан эд зүйлийн үнийн дүнг 3 дахин өсгөсөн үнээр худалдагчид торгууль төлөх бөгөөд энэ зөрчил давтагдвал худалдагч уг гэрээг цуцална.

Зургаа. Талуудын хүлээх эрх, үүрэг

6.1 Худалдагч тал гэрээнд заасан хугацаанд хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3%-ийн алдангийг захиалагчид төлөх үүрэгтэй.

6.2 Худалдан авагч тал гэрээний 5.3-т заасан хугацааг хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3%-ийн алдангийг худалдагч талд төлөх үүрэгтэй.

6.3 Торгууль алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

6.4 "ДЦС-4" ТӨХК-ийн Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Компаний дотоод журмыг зөрчсөнөөс, түүнчлэн өөрсдийн буруугаас тоног төхөөрөмж гэмтээсэн, үйлдвэрлэлийн осол гэмтэл гаргасны улмаас учирсан хохирлыг худалдан авагч байгууллага хариуцаж, хохирлыг барагдуулна.

6.5 Худалдан авагч талын ажиллагсад хулгай хийсэн болон хулгайн хэрэгт холбогдсон нь тогтоогдвол хулгайлсан эд зүйлийн үнийн дүнг 3 дахин өсгөсөн үнээр худалдагчид торгууль төлнө.

6.6 Гэрээний хугацаа дуусахад 2 тал хамтарч гэрээг дүгнэнэ.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл /Форсмажор/

7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэнд өртөх, газар хөдлөх, зуд болох, бусад байгалийн хүчин зүйл мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагаар гэрээг цуцлана.

7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэх хүртэлх эрсдлийг худалдагч, шилжүүлэн авснаас хойшхийг худалдан авагч хариуцна.

7.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд Форсмажорын нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

7.5 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд Ковид цар тахалтай холбоотой үүссэн нөхцөлийг тооцохгүй бөгөөд улмаар гэрээний үндсэн үүрэг биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Эрх бүхий газраас нийтэд мөрдөх захиргааны хэм хэмжээний акт гараагүй тохиолдолд талууд хариуцлагаас чөлөөлөгдөх /торгууль, алданги төлөх үүргээс чөлөөлөх/-гүй. Ковид цар тахалтай холбоотой асуудлаар талууд

Худалдагч :

Худалдан авагч:



харилцан тохиролцож , гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг түр хойшлуулах гэх мэт гэрээнд өөрчлөлт оруулж болно.

Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах

- 8.1 Аль нэг тал гэрээнд заасан үүргээ зөрчсөн, зохих ёсоор биелүүлээгүй буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрэв талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцож хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарснаар хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Талуудын аль нэг нь гэрээнээс татгалзах бол нөгөө талдаа 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдлийг хүлээн авсан тал 10 хоногийн дотор уг мэдэгдлийн талаар өөрийн байр суурь, саналыг бичгээр хариу мэдэгдэнэ. Хэрэв гэрээг биелүүлэх боломжгүй болох нь тодорхой бол нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.

Ес. Бусад зүйл

- 9.1 Талууд энэхүү гэрээг Монгол хэл дээр 3% үйлдэж захиалагч тал 1% -ыг гүйцэтгэгч тал 2% -ийг хадгалах ба тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй.
- 9.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Худалдагч талыг төлөөлж:

ДЦС-4" ТӨХК-ИЙН
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БАГ ЭСД ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР Б.ГАНХУЯГ
2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР

БЕЗНИС ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ДЭД
ЗАХИРАЛ..... Б.САНДУЙЖАВ
2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР

БМА-НЫ ДАРГА.....
..... С.АЛТАНХУЯГ
2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР


СБХ-ИЙН ДАРГА.....
..... Д.ТӨМӨРТОО
2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ
..... Ч.БЯМБАСҮРЭН
2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН
..... С.ДОНИД
2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР

Худалдагч:

Худалдан авагч:



Худалдан авагч талыг төлөөлж:

"БИ ЭЛ БИ ЖИ" ХХК- ИЙН

ЗАХИРАЛ

Г.БАТ-ӨЛЗИЙ

2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР

АЛБАН ЁСНЫ ХАЯГ

РД:2688352

Харилцах банк:ХХБ 806-р салбар

Дансны дугаар: 406001049

Харилцах банк: Төрийн банк

Дансны дугаар:102100001107

Харилцах банк:ХААН банк

Дансны дугаар:5038008126

Харилцах банк:Голомт банк

Дансны дугаар:1102038052

Харилцах банк:Капитал банк

Дансны дугаар:2002017630

Харилцах утас:7000-2245

7017-0783

7000-1184

Байршлын хаяг:

Баянгол дүүрэг 20-р хороо

Эрчим хүчний гудамж

РД: 6405169

Харилцах банк:

Дансны дугаар:

Нэхэмжлэх хүлээн авах

албан ёсны и-мэйл хаяг:

Харилцах утас: 99960466

Байршлын хаяг:

СХД 31-р хороо АЛТАЙ -2.193

Худалдагч :

Худалдан авагч:



